



Захиргааны хэм хэмжээний
актын улсын нэгдсэн санд
2020 оны 04 сарын 28-ны
өдрийн 473 дугаарт бүртгэв.

МОНГОЛ УЛСЫН
СОНГУУЛИЙН ЕРӨНХИЙ ХОРООНЫ
ТОГТООЛ

2020 оны 4 сарын 14 өдөр

Дугаар 21

Улаанбаатар хот

Цахим орчин ашиглан сонгуулийн сурталчилгаа
явуулах, түүнд хяналт тавих журам батлах тухай

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.9 дэх хэсэг, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.9 дэх хэсэг, Сонгуулийн төв байгууллагын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.7 дахь заалт, 12 дугаар зүйлийн 12.3 дахь хэсгийг тус тус үндэслэн Монгол Улсын Сонгуулийн ерөнхий хорооноос ТОГТООХ нь:

1. "Цахим орчин ашиглан сонгуулийн сурталчилгаа явуулах, түүнд хяналт тавих журам"-ыг 1 дүгээр хавсралтаар, "Сонгуулийн сурталчилгаанд ашиглах цахим хуудасны бүртгэл"-ын маягтыг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Энэхүү журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Цагдаагийн ерөнхий газар /С.Баатаржав/, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар /Н.Цагаанхүү/, Шударга, өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар /Б.Лхагва/, Харилцаа холбооны зохицуулах хороо /Г.Чинзориг/-нд тус тус даалгасугай.

ДАРГА

Ч. Содномцэрэн

Ч.СОДНОМЦЭРЭН

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

Ц. Болдсайхан

Ц.БОЛДСАЙХАН



Монгол Улсын Сонгуулийн ерөнхий хорооны
2020 оны 4 дугаар сарын 14-ны өдрийн
21 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт

ЦАХИМ ОРЧИН АШИГЛАН СОНГУУЛИЙН СУРТАЛЧИЛГАА ЯВУУЛАХ, ТҮҮНД ХЯНАЛТ ТАВИХ ЖУРАМ

Нэг. Ерөнхий зүйл

1.1. Энэхүү журмаар Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.2.7 дахь заалт, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.2.7 дахь заалтад заасан цахим орчин ашиглан сонгуулийн сурталчилгаа явуулах болон түүнд хяналт тавихтай холбогдон гарах харилцааг зохицуулна.

1.2. Сонгуульд оролцож буй нам, эвсэл, нэр дэвшигч, тэдгээрийг төлөөлсөн этгээд нь цахим орчинд сонгуулийн сурталчилгаа явуулахдаа сонгуулийн хууль тогтоомж болон энэ журмыг дагаж мөрдөнө.

1.3. Үүрэн холбооны үйлчилгээ эрхлэгч, интернэтийн үйлчилгээ эрхлэгч болон цахим орчны үйлчилгээ эрхлэгч (цахим хуудас, цахим орчин дахь олон нийтийн сүлжээ, аппликэйшн, гэх мэт) нь сонгуулийн сурталчилгааны хугацаанд энэ журмын 1.2-т заасан хууль тогтоомж, журмыг мөн адил дагаж мөрдөнө.

1.4. Энэ журмын 1.2-т заасан этгээд нь цахим шуудан, цахим хуудас болон цахим орчин дахь олон нийтийн сүлжээний цахим хуудсыг ашиглан сонгуулийн сурталчилгаа явуулж болно.

Хоёр. Баримтлах зарчим

2.1. Сонгуулийн сурталчилгааг цахим орчинд явуулахдаа нам, эвсэл, нэр дэвшигчийн мэдээлэл /нэр, далбаа, таних тэмдэг, сонгуулийн уриа/-ийг олон нийтэд ойлгомжтой, ил тод харагдахуйц байдлаар нийтэлнэ.

2.2. Сонгуульд нэр дэвшигчийн бүртгэлтэй цахим хаяг, цахим хуудас нь аливаа мэдээ, мэдээллийг нийтлэхдээ албан бус цахим хаяг, цахим хуудаст нийтлэгдсэн мэдээллийг эх сурвалжаа болгон ашиглахгүй.

Гурав. Сонгуулийн сурталчилгаанд ашиглах цахим хуудасны бүртгэл

3.1. Нам, эвсэл, нэр дэвшигч нь Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2 дахь хэсэг, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.2 дахь хэсэгт заасны дагуу сонгуулийн сурталчилгаанд ашиглах цахим хуудас ашиглах тохиолдолд аймаг, нийслэлийн сонгуулийн хороонд бүртгүүлнэ.

3.2. Цахим хуудсыг бүртгүүлэхдээ дараах мэдээллийг хавсаргаж хүргүүлнэ:

3.2.1. Сонгуулийн ерөнхий хорооноос баталсан бүртгэлийн хуудас;

3.2.2. цахим хуудасны домэйн нэр, вэб хуудас болон вэб сайтын байршлын (вэб/сервер хостинг) талаарх мэдээлэл;

3.2.3.цахим орчин дахь олон нийтийн сүлжээний цахим хуудасны бүртгэлийн хаяг, бүртгүүлсэн нэр, цахим шуудан, утасны дугаар, цахим холбоос хаяг (URL хаяг).

3.3.Аймаг, нийслэлийн сонгуулийн хороо нь нам, эвсэл, нэр дэвшигчийн сонгуулийн сурталчилгаанд ашиглах цахим хуудасны бүртгэлийн мэдээллийг бүртгэл хийснээс хойш нэг хоногийн дотор Харилцаа холбооны зохицуулах хороонд цахим хэлбэрээр хүргүүлнэ.

3.4.Нам, эвсэл, нэр дэвшигчийн бүртгүүлсэн цахим хуудасны жагсаалтыг Сонгуулийн ерөнхий хороо болон Харилцаа холбооны зохицуулах хороо нь өөрийн албан ёсны цахим хуудсаар мэдээлнэ.

3.5.Нам, эвсэл, нэр дэвшигч нь цахим хуудас болон цахим шуудангийн мэдээллээ аливаа халдлагаас урьдчилан сэргийлэх, мэдээллийн аюулгүй байдлыг хангах талаар арга хэмжээ авч хэрэгжүүлсэн байна.

Дөрөв. Сонгуулийн сурталчилгааны хяналтын горим

4.1.Цахим орчин дахь сонгуулийн сурталчилгаатай холбоотой өргөдөл, гомдлыг цагдаагийн байгууллага, шударга өрсөлдөөний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, мэргэжлийн хяналтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад гаргана.

4.2.Энэ журмын 4.1-д заасан эрх бүхий байгууллага нь цахим орчин дахь сонгуулийн сурталчилгаатай холбоотой өргөдөл, гомдлыг хүлээн авч холбогдох хууль тогтоомжийн дагуу хянан үзээд санал, дүгнэлтийг Харилцаа холбооны зохицуулах хороонд хүргүүлнэ.

4.3.Энэ журмын 4.2-т заасан санал, дүгнэлтэд тухайн мэдээ, мэдээллийн цахим хаяг, цахим холбоос, хэвлэмэл баримт зэрэг шаардлагатай баримтыг хавсаргана.

4.4.Харилцаа холбооны зохицуулах хороо нь энэ журмын 4.2-д заасан санал, дүгнэлтийн дагуу дараах мэдэгдлийг цахим орчны үйлчилгээ эрхлэгчдэд даруй¹ хүргүүлнэ:

4.4.1.мэдэгдэлд дурдсан мэдээ, мэдээллийг устгах эсвэл хандалтыг хязгаарлах;

4.4.2.мэдэгдэлд дурдсан цахим хаяг, цахим хуудсыг сонгуулийн сурталчилгааны хугацаа дуустал хандалтыг хязгаарлах.

4.5.Цахим орчны үйлчилгээ эрхлэгч нь энэ журмын 4.4-т заасан мэдэгдэлд дурдсан арга хэмжээг заасан хугацаанд даруй хэрэгжүүлж, хэрэгжилтийн талаарх мэдээллийг Харилцаа холбооны зохицуулах хороонд цахим шуудан, утсаар мэдэгдэж, албан бичгээр хүргүүлнэ.

4.6.Цахим орчны үйлчилгээ эрхлэгчийг олж тогтоох боломжгүй эсхүл энэ журмын 4.4-т заасан арга хэмжээг хэрэгжүүлээгүй бол Харилцаа холбооны зохицуулах хороо дараах мэдэгдлийг үүрэн холбооны үйлчилгээ эрхлэгч болон интернетийн үйлчилгээ эрхлэгчид хүргүүлнэ:

4.6.1.тухайн цахим орчны үйлчилгээ эрхлэгчийн Монгол Улсаас хандах хандалтыг сонгуулийн сурталчилгааны хугацаа дуустал хязгаарлах;

¹ Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 1.4 дүгээр зүйлийн 1.7."даруй" гэж боломжит богино хугацааг;

4.6.2.хуульд заасан технологийн арга хэмжээ авах.

4.7.Үүрэн холбооны үйлчилгээ эрхлэгч болон интернэтийн үйлчилгээ эрхлэгч нь энэ журмын 4.6-д заасан мэдэгдэлд дурдсан арга хэмжээг заасан хугацаанд даруй хэрэгжүүлэх үүргийг хүлээх бөгөөд хэрэгжилтийн талаарх мэдээллийг Харилцаа холбооны зохицуулах хороонд цахим шуудан, утсаар мэдэгдэж, албан бичгээр хүргүүлнэ.

4.8.Харилцаа холбооны зохицуулах хороо нь энэ журмын 4.4-т заасан мэдэгдлийг тухайн цахим орчны үйлчилгээ эрхлэгчийн цахим орчин дахь хаяг эсхүл Харилцаа холбооны зохицуулах хороонд бүртгэлтэй цахим шуудангаар хүргүүлснээр мэдэгдсэнд тооцно.

Тав. Эрх бүхий байгууллагуудын хамтын ажиллагаа

5.1.Сонгуулийн хууль тогтоомжийн хэрэгжилтийг цахим орчинд түргэн шуурхай хангуулах хүрээнд холбогдох эрх бүхий байгууллагууд хамтран ажиллана.

5.2.Энэ журмын 5.1-д заасан эрх бүхий байгууллага гэдэгт Сонгуулийн ерөнхий хороо, тагнуулын байгууллага, цагдаагийн байгууллага, шударга өрсөлдөөний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, мэргэжлийн хяналтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, Харилцаа холбооны зохицуулах хороо хамаарна.

5.3.Эрх бүхий байгууллагууд нь хамтран ажиллах албан тушаалтны овог, нэр, албан тушаал, хөдөлгөөнт болон суурин утасны дугаар, факсын дугаар, цахим хаягийн жагсаалтыг гаргасан байна.

5.4.Эрх бүхий байгууллагууд нь цахим орчин дахь хууль бус сонгуулийн сурталчилгаатай холбоотой санал, дүгнэлтийг цахим шуудан хаяг, факсаар даруй холбогдох газарт хүргүүлэх бөгөөд албан бичгийг шуудангаар хүргүүлнэ.

5.5.Эрх бүхий байгууллагууд нь энэ журмын 5.4-т заасан санал, дүгнэлт, шийдвэрийг цахим шуудангаар хүлээж авсан даруйд холбогдох арга хэмжээг авч, авсан арга хэмжээний талаарх мэдээллийг даруй мэдэгдэнэ.

Зургаа. Бусад холбогдох байгууллагын эрх үүрэг

6.1.Үүрэн холбооны үйлчилгээ эрхлэгч болон интернэтийн үйлчилгээ эрхлэгч нь дараах үүрэгтэй:

6.1.1.сонгуулийн хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах үүднээс шийдвэр гаргах эрх бүхий болон техникийн ажилтан тус бүр нэг, нийт хоёр албан тушаалтныг сонгуулийн сурталчилгааны хугацаанд хамтран ажиллах төлөөлөгчөөр томилж, овог, нэр, албан тушаал, хөдөлгөөнт болон суурин утасны дугаар, цахим шуудангийн хаягийг Харилцаа холбооны зохицуулах хороонд бүртгүүлэх;

6.1.2.сонгуулийн сурталчилгаа эхэлснээс сонгуулийн санал авах өдрийн дараах өдөр хүртэл хугацаанд энэ журмыг хэрэгжүүлэхтэй холбоотой үйл ажиллагааг тасралтгүй явуулах нөхцөл бололцоогоор хангах;

6.1.3.Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 47.8, 47.11 дэх хэсэг, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 46.8, 46.11 дэх хэсэгт заасан чиг үүргийн хэрэгжилтийг хангуулах хүрээнд сонгуулийн сурталчилгааны хугацаа эхлэхээс өмнө туршилтыг хийх, техник технологийн бэлэн байдлыг хангасан байх;

6.1.4.интернэтийн үйлчилгээ эрхлэгч нь зөрчилтэй домэйн нэрийн жагсаалт /black-list.mn/-ыг өөрийн сүлжээнд даруй хязгаарлах;

6.1.5. зөрчилтэй домэйн нэрийн жагсаалтыг сонгуулийн сурталчилгаа эхэлснээс сонгуулийн санал авах өдрийн дараахь өдөр хүртэл хугацаанд 4 цаг тутамд шинэчлэх;

6.1.6. интернэтийн үйлчилгээ эрхлэгч нь домэйн нэрийн сервер (Domain Name Server)-тээ болон сүлжээний хамгаалалтын төхөөрөмж (Firewall)-дөө "www.black-list.mn" домэйн нэрт харгалзах АйПи(IP) хаягаас ирэх домэйн нэрийн асуулга, хүсэлтийг зөвшөөрөх, хариулах боломжийг бүрдүүлсэн байх;

6.1.7. интернэтийн үйлчилгээ эрхлэгч нь интернэтийн үйлчилгээнд ашиглаж буй домэйн нэрийн серверүүд (Domain Name Server)-ийн АйПи (IP) хаягууд болон хариуцан ажилладаг ажилтны овог, нэр, албан тушаал, цахим шуудангийн хаяг, утасны дугаар зэрэг мэдээллийг Харилцаа холбооны зохицуулах хороонд бүртгүүлэх.

6.2. Цахим орчны үйлчилгээ эрхлэгч нь дараах үүрэгтэй:

6.2.1. сонгуулийн хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах үүднээс шууд харилцах төлөөлөгчийг томилж, хөдөлгөөнт болон суурин утасны дугаар, цахим шуудангийн хаягийг Харилцаа холбооны зохицуулах хороонд бүртгүүлсэн байх;

6.2.2. энэ журмын 4.4-т заасан мэдэгдэлд дурдсан арга хэмжээг хэрэгжүүлэх, гүйцэтгэх техник технологийн боломжийг заавал хангасан байх;

6.2.3. нам, эвсэл, нэр дэвшигчийн цахим хуудас болон бусад цахим хуудсаар сонгуулийн сурталчилгаа явуулахдаа сэтгэгдэл бичигдэхгүй тохиргоотойгоор нийтлэх;

6.2.4. сонгуулийн сурталчилгаа явуулахдаа нам, эвсэл, нэр дэвшигчийн мэдээлэл /нэр, далбаа, таних тэмдэг, сонгуулийн уриа/-ийг олон нийтэд ойлгомжтой, ил тод харагдахуйц байдлаар нийтлэх;

6.2.5. нам, эвсэл, нэр дэвшигчийн цахим орчин дахь олон нийтийн сүлжээний цахим хуудсыг баталгаажуулах.

6.3. Сонгуульд оролцож буй нам, эвсэл, нэр дэвшигч нь дараах үүрэгтэй:

6.3.1. сонгуулийн сурталчилгаанд цахим орчин дахь олон нийтийн сүлжээний тус бүр нэг цахим хаяг, цахим хуудас ашиглах;

6.3.2. сонгуулийн сурталчилгаанд ашиглах цахим хуудас, цахим хаягийг Сонгуулийн ерөнхий хорооноос баталсан бүртгэлийн хуудасны дагуу аймаг, нийслэлийн сонгуулийн тойргийн хороонд бүртгүүлэх;

6.3.3. цахим шуудангаар сонгогчдод хүргүүлж буй сурталчилгааны материалыг хэрэв сонгогч цаашид хүлээж авахаас татгалзсан тохиолдолд дахин хүлээн авахгүй байх боломжийг хангасан байх.

Долоо. Гомдол маргаан шийдвэрлэх

7.1. Үүрэн холбооны үйлчилгээ эрхлэгч, интернэтийн үйлчилгээ эрхлэгч болон цахим орчны үйлчилгээ эрхлэгч нь хүн, хуулийн этгээдийн гомдол маргааныг хүлээж авах шуудангийн хаяг, холбоо барих утасны дугаар, цахим шуудангийн хаягийг олон нийтэд ил тод байршуулна.


7.2. Үүрэн холбооны үйлчилгээ эрхлэгч, интернэтийн үйлчилгээ эрхлэгч болон цахим орчны үйлчилгээ эрхлэгч нь хүн, хуулийн этгээдийн гомдол, маргаантай холбоотой асуудлыг өөрийн эрх хэмжээний хүрээнд шийдвэрлэх бөгөөд шаардлагатай бол холбогдох эрх бүхий байгууллагад хандаж болно.

7.3. Үүрэн холбооны үйлчилгээ эрхлэгч, интернэтийн үйлчилгээ эрхлэгч, цахим орчны үйлчилгээ эрхлэгч нь хүн, хуулийн этгээдийн гомдол, маргааныг хэрхэн шийдвэрлэсэн талаарх тайланг сонгуулийн сурталчилгааны хугацаа дууссанаас хойш 30 хоногийн дотор гаргаж, олон нийтэд нээлтэй мэдээлнэ.


Найм. Хариуцлага

8.1.Энэ журмыг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Зөрчлийн тухай хууль болон холбогдох бусад хуульд заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

---oOo---



Монгол Улсын Сонгуулийн ерөнхий хорооны
2020 оны 4 дугаар сарын 14-ны өдрийн
21 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт



**СОНГУУЛИЙН СУРТАЛЧИЛГААНД АШИГЛАХ
ЦАХИМ ХУУДАСНЫ БҮРТГЭЛ**

1.Нэр дэвшигчийн бүртгэл

Овог: <input type="text"/>	Нам, эвсвэл: <input type="text"/>
Нэр: <input type="text"/>	Нэр дэвшиж буй тойргийн дугаар: <input type="text"/>

2.Цахим хуудас

/МУИХСТХ-ийн 47.1.1.нэр дэвшигчийн болон нам, эвслийн өөрийн тус бүр нэг цахим хуудас/

Нэр дэвшигчийн вэбсайтын бүртгэлийн мэдээлэл	Тус вэбсайтын байршлын талаарх мэдээлэл (вэб сервер / хостинг)
Домэйн нэр: <input type="text"/>	Хост серверийн нэр: <input type="text"/>
Мэйл хаяг: <input type="text"/>	Хост серверийн IP хаяг: <input type="text"/>
Утасны дугаар: <input type="text"/>	

3.Цахим орчин дахь олон нийтийн сүлжээний цахим хуудас


/МУИХСТХ-ийн 47.1.2.цахим орчин дахь олон нийтийн цахим хуудас, 47.1.3.бусад цахим хуудас/

Цахим орчин дахь олон нийтийн сүлжээ	Олон нийтийн сүлжээний цахим хуудасны мэдээлэл
<input type="checkbox"/> Нэр дэвшигчийн Фэйсбүүк:	Фэйсбүүк хаяг: Фэйсбүүк хаягийн нэр: Фэйсбүүк хаягийн хэрэглэгчийн нэр: <input type="text"/> <input type="text"/>
	Фэйсбүүк хаягийн холбоос: <input type="text"/>
	Фэйсбүүк хуудас: Фэйсбүүк хуудасны нэр: Фэйсбүүк хуудасны дугаар /ID/: <input type="text"/> <input type="text"/>
	Фэйсбүүк хуудасны холбоос: <input type="text"/>

<input type="checkbox"/> Бусад олон нийтийн сүлжээ	Бусад олон нийтийн сүлжээний цахим хуудас:	
	Олон нийтийн сүлжээний нэр:	Цахим хуудасны холбоос:
	<input type="text"/>	<input type="text"/>
	Олон нийтийн сүлжээний нэр:	Цахим хуудасны холбоос:
<input type="text"/>	<input type="text"/>	
Олон нийтийн сүлжээний нэр:	Цахим хуудасны холбоос:	
<input type="text"/>	<input type="text"/>	
Олон нийтийн сүлжээний нэр:	Цахим хуудасны холбоос:	
<input type="text"/>	<input type="text"/>	

*Цахим орчин олон нийтийн сүлжээний цахим хуудас, цахим хаягийн профайлыг хэвлэмлээр хавсаргах

4.Бүртгэл хийсэн аймаг, нийслэлийн сонгуулийн хороо



<input type="checkbox"/> Нийслэлийн сонгуулийн хороо	
<input type="checkbox"/> Аймгийн сонгуулийн хороо	<input type="text"/>
Баталгаажуулсан	
Овог, нэр:	<input type="text"/>
Албан тушаал:	<input type="text"/>
Гарын үсэг:	<input type="text"/>